

Байгаль дахь усны эргэлт

10 анги

- Нарны илч усны эргэлтэд чухал шаардлагатай эрчим хүчийг хангаж өгдөг.
- Нар далай тэнгисийн усыг ууршуулдаг.
- Үл үзэгдэх усны уур агаар мандалд дэгдэж хүйтэн агаарт гарна.
- Усны уур конденсацид орж үүл болно.
- Галт уулаас савсах уурнаас үүл бий болно.
- Агаарын урсгал үүлсийг дэлхийн өнцөг булан тийш зөөнө.
- Хүйтэн уур амьсгалтай газарт хур тунадас цас, мөс, мөсөн гол болон хуримтлагддаг.
- Цас хайлж урссаар гол мөрөн, далай тэнгист нийлэх юм уу газарт шингэдэг.
- Мөс заримдаа хайлалгүйгээр шууд агаарт ууршихыг сублимаци гэнэ.

Усны эргэлт



- Газарт орсон хур бороо гадаргаар урссаар гол мөрөн, нуур, далай тэнгисийг усаар тэтгэнэ.
- Борооны ус газарт шингэн доош нэвчиж, хангалттай гүнд хүрч чадвал газрын доорх усыг тэжээдэг.
- Гол нууруудын ус газарт нэвчинэ.
- Татах хүч, даралтын нөлөөгөөр ус газар дор шилжин хөдөлж байдаг.
- Газрын гадаргад ойр орших гүний усыг ургамлууд шингээн авдаг.
- Газрын доорх ус гол нууруудыг тэжээхээс гадна булаг, рашаан болон газрын гадаргад урсан гардаг.
- Ургамал газрын доорх усыг шингээн авч, навчаараа дамжуулан ууршуулдаг. Үүнийг транспираци гэнэ.
- Газрын доорх усны зарим нь газрын бүр гүнд очдог ба тэндээ их уддаг.
- Газрын доорх ус далай тэнгис рүү урсан очиж усны эргэлтийг үргэлжлүүлдэг.